



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 5/35

Чингис хот

М.Урандолгионыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2014 оны “Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай” 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Туршилтын хугацаанд хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан Мягмарбаатарын Урандолгионыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтнээр 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. М.Урандолгионы цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 509948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найман/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл гомдол, дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Урандолгионд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР